“ХҮРД” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Дугаар: 01 Улаанбаатар хот

“Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай”

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн ... дугаар зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100 хувийн ирцтэй хуралдаж, олонхын санал авсан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн **Б.Мөнхбатыг** тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосугай.

Хоёр. Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга **Б.Мөнхбат**-д Компанийн тухай хуулийн 78.2 дугаар зүйлд заасан ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хурал хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

Гурав. ТУЗ-ийн дарга өөрчлөгдсөнтэй холбогдуулан компанийн хуулийн этгээдийн мэдээллийн өөрчлөлтийг холбогдох хуулийн хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тогтоолыг баталсан өдрөөс буюу 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ..... **Б.МӨНХБАТ**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

..... Э.УНДРАХ
..... Э.ТЭМҮҮЖИН
..... Б.БАТ-ЭРДЭНЭ
..... Б.СУМЪЯА
..... Б.ГАНТУЯА
..... Х.ЦЭВЭЛМАА
..... Э.БАТЗОРИГ
..... Э.МӨНХ-ОРГИЛ

“ХҮРД” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Дугаар: 02 Улаанбаатар хот

“Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх” хороод байгуулах тухай

Компанийн тухай хуулийн холбогдох заалт, Компанийн дүрмийн холбогдох заалт, Монголын компанийн засаглалын кодексын холбогдох заалтуудыг тус тус үндэслэн, компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх, хяналтын чиг үүргийг сайжруулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаас **ТОГТООХ** нь:

Нэг. “Хүрд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нийт гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дараах төрөлжсөн байнгын хороодыг байгуулсугай.

- Аудитын хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо

Хоёр. ТУЗ-ийн дэргэдэх хороодод тавигдах хуулийн шаардлага болон гүйцэтгэх үндсэн чиг үүргийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Шинээр байгуулагдсан хороодын дарга болон гишүүдийн бүрэлдэхүүнийг Төлөөлөн удирдах зөвлөлийн **дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн сонгож, батлахаар** тогтоосугай.

Дөрөв. Хороодын ажиллах дэг, журмын төслийг боловсруулж, ТУЗ-ийн дараагийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад даалгасугай.

Тав. Хороодын үйл ажиллагааны хуралдааны зардал, гишүүдийн урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас (ХЭХ) баталсан ТУЗ-ийн жилийн төсвийн хүрээнд зохицуулж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжинд зөвшөөрсүгэй.

Зургаа. Энэхүү шийдвэрийг баталсан өдрөөс буюу **2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс** эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ..... Б.МӨНХБАТ

“ХҮРД” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Дугаар: ...03 Улаанбаатар хот

“Салбар нэгж шинээр байгуулахыг зөвшөөрөх тухай”

Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ыг тус тус үндэслэн, компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Хүрд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нийт гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Охин компани болох “Хүрд Финанс ББСБ” ХХК-ийн санхүүгийн үйлчилгээг иргэд, харилцагчдад түргэн шуурхай хүргэх, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх зорилгоор **Увс аймгийн Улаангом суманд** компани харьяа салбар нэгжийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Шинээр байгуулагдах салбарын чиглэлээр **Увс аймгийн санхүүгийн зах зээлийн судалгаа, эрсдэлийн үнэлгээ болон ТЭЗҮ (Бизнес төлөвлөгөө)-ийг боловсруулах**, СЗХ-ны "Тохиромжтой этгээд"-ийн шалгуурт нийцсэн **удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг сонгон шалгаруулж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийхийг** Хүрд финанс ББСБ ХХК-ийн гүйцэтгэх захирал **Г.Цэцгээ**-д даалгасугай.

Гурав. Салбар нэгжийн байрны дотоод зохион байгуулалт, техник тоног төхөөрөмж, аюулгүй байдлын доод стандарт (камер, дохиолол, сейф)-ыг хангах, тухайн үйл ажиллагаанд шаардагдах **судалгаа, хүний нөөцийн болон үйл ажиллагааны төсвийг** санхүүжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүрд финанс ББСБ ХХК-ийн гүйцэтгэх захирал **Г.Цэцгээ**-д даалгасугай.

Дөрөв. Салбар нэгж шинээр байгуулах тухай ТУЗ-ийн тогтоол, холбогдох баримт бичгийн иж бүрдлийг хангаж Санхүүгийн зохицуулах хороонд хуулийн хугацаанд хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авах, зөвшөөрөл гарсны дараа тухайн орон нутгийн Улсын бүртгэлийн байгууллага болон Татварын хэлтэст бүртгүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг “Хүрд” ХК-ийн Гүйцэтгэх захирал **Э.Тэмүүжин**-д үүрэг болгосугай.

Тав. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга **Б.Мөнхбат**-д даалгасугай.

Энэхүү тогтоолыг баталсан өдрөөс буюу 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ..... Б.МӨНХБАТ

“ХҮРД” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Дугаар: ...04 Улаанбаатар хот

“Үл хөдлөх хөрөнгө захиран зарцуулах тухай”

Компанийн хөрөнгийн үр ашигтай ашиглалт, хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор “Хүрд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нийт гишүүдийн 100 хувийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг: Баянзүрх дүүргийн 43 дугаар хороонд байрлах “Хүрд Өргөө” хотхоны 109 дүгээр байрны “Хүрд” ХК-ийн өмчлөлд бүртгэлтэй 57 ширхэг дулаан зогсоолуудыг худалдан борлуулж, хөрөнгийг эргэлтэд оруулсугай.

Хоёр: “Хүрд Өргөө” хотхоны 109 дүгээр байрны “Хүрд” ХК-ийн өмчлөлд бүртгэлтэй 11 тоот, 17 тоот, 29 тоот, 84 тоот орон сууцуудыг худалдан борлуулсугай.

Гурав: Энэхүү тогтоолын 1, 2 дахь хэсэгт заасан үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах, өмчлөх эрхийн гэрчилгээ гаргуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, үл хөдлөх хөрөнгийн үнэ, төлбөрийн нөхцөлийг тогтоох, худалдан борлуулах, худалдан авагчтай хэлцэл хийх, захиалга, урьдчилгаа, худалдах-худалдан авах болон бусад холбогдох гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, төлбөр хүлээн авах, үл хөдлөх хөрөнгө хүлээлцэх, өмчлөх эрх шилжүүлэх, холбогдох төрийн болон бусад байгууллагад “Хүрд” ХК-ийг төлөөлөх, шаардлагатай өргөдөл, хүсэлт, мэдүүлэг, гэрээ, акт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах зэрэг шаардлагатай бүх ажиллагааг хууль тогтоомж болон компанийн дүрэм, дотоод журмын хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг “Хүрд” ХК-ийн Гүйцэтгэх захирал **Э.Тэмүүжинд** олгосугай.

Дөрөв. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг “Хүрд” ХК-ийн Гүйцэтгэх захирал **Э.Тэмүүжинд**, хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ..... **Б.МӨНХБАТ**